

**Тэтгэлийн зээлийн хүүг бууруулахтай холбоотойгоор  
“Банкны тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төслийн танилцуулга**

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн зааснаар манай улс иргэдийн нийгмийн баталгааг хангах үүргийг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан.

Дээрх үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хууль” “Банкны тухай хууль” “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-иудыг тус тус баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дах хэсэгт зааснаар **“тэтгэвэр”** гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүссэн даатгуулагч, хүнд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ гэж зааж өгсөн байна.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай”-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар тэтгэвэрийг :

1. өндөр насны;
2. хөдөлмөрийн чадвар алдсаны;
3. тэжээгчээ алдсаны гэсэн төрлүүдтэй байхаар хуульчилжээ.

Дээрх тэтгэвэр авагч иргэдийн орлогын эх үүсвэр нь “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль”-д заасны дагуу үүсч байгаа билээ. Нэгэнт байнгын тогтвортой орлоготой байх тул “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг, мөн хуулийн 20 дугаар зүйл, Иргэний хуулийн 451 дүгээр зүйлд тус тус заасны дагуу зээлийн гэрээ байгуулах эрх үүсэж байгаа болно. Хуулийн энэхүү зохицуулалтад зээлийн гэрээ байгуулах эрхтэй эсэх болон зээлийн гэрээний нийтлэг зохицуулалтуудыг л тусгасан байна.

Харин банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд **зээлийн хүүг өөрөө тогтооно**” гэж нарийвчлан хуульчилж өгчээ. **Тэтгэврийн зээл нь мөн л адил энэхүү зохицуулалтын дагуу олгогдож байгаа болно.** Гэвч нь хуулийн энэхүү зохицуулалт нь зарим төрлийн нийгмийн харилцаанд төрөөс баримталж буй бодлогод нийцэхгүй байгаа билээ.

Учир нь тэтгэврийн зээлийн гол зорилго нь өндөр настай иргэдийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн байдаг билээ. Энэхүү зорилгыг баталгаажуулж хууль

тогтоогчийн зүгээс “Ахмад настны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ” гэж хуульчилж өгсөн. Цаашлаад ахмад настны нийгмийн баталгааг хангахад дан ганц орлогыг нэмэгдүүлэхээс гадна зээлийн хүүг багасгах шаардлагатай.

Гэвч дээр дурдсанчлан зээлийн хүүг банк өөрөө тогтооно гэж хуульчилж өгсөн байх тул ахмад настны тэтгэврийн зээлийн хүүг багасгахын тулд банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна гэж үзлээ.